



**ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/03

Мандалговь

Нийтээр тэмдэглэх баярын амралтын
өдрүүдэд хариуцлагатай жижүүр ажиллуулах
тухай


Монгол Улсын Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, БОНХ-ийн сайдын 2013 оны А-321 дугаар тушаалаар батлагдсан тус Хамгаалалтын захиргааны дүрмийн 2 дугаар бүлгийн 2.5.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын уламжлалт сар шинийн баярын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдын хуваарь, онцгой тохиолдолд холбогдох албан байгууллагуудын утасны жагсаалтуудыг 1 дүгээр, гүйцэтгэх үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2018 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 18-ныг дуустал хугацаанд хуваарийн дагуу санаачлагатай ажиллаж, тусгай дэвтэрт тэмдэглэл хөтлөн, хүлээлцэж байхыг албан хаагчдад үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хуулийн хэрэгжилт, хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн / А.Цэцэгдэлгэр /-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.БАТТУВШИН

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Их газрын чулууны хамгаалалтын захиргааны хариуцлагатай жижүүрийн нэрс, хуваарь

№	Овог нэр	02 сарын 16	02 сарын 17	02 сарын 18
1	Ш.Намсрайжав	08 ⁰⁰ -15 ⁰⁰		
	Б.Цэрэнмягмар	14 ⁰⁰ -22 ⁰⁰		
2	Н.Гэрэлмаа		08 ⁰⁰ -15 ⁰⁰	
	Г.Баярсайхан		14 ⁰⁰ -22 ⁰⁰	
3	А.Цэцэгдэлгэр			08 ⁰⁰ -15 ⁰⁰
	Б.Пүрэвгүр			14 ⁰⁰ -22 ⁰⁰

Онцгой тохиолдолд холбогдох байгууллагуудын утасны жагсаалт

№	Байгууллагын нэр	Утас
1	БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн Б.Дэлгэрцэцэг	94100223
2	Дундговь аймгийн Онцгой байдлын газар	7059101
3	Дундговь аймгийн Цагдаагийн газар	7059102
4	Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг	7059103

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/03 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Хариуцлагатай жижүүрийн гүйцэтгэх ажил үүрэг:

1. Томилогдсон жижүүр нь батлагдсан хуваарийн дагуу ажлын байранд сууж ажиллах
2. Ирсэн мэдээллийг цаг минутаар нь бүртгэж, хариуцлагатай жижүүрээр ажилласан тэмдэглэлээ бичиж дараагийн жижүүрт хүлээлгэн өгөх
3. Байгууллагын гадна орчин болон доторх ус, цахилгаан, тасалгааны лац ломбо бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, галын аюулгүй байдлыг сахиж ажиллах
4. Жижүүртэй үед орсон гарсан хүмүүсийг бүртгэх
5. Байгаль хамгаалагч нараас 24 цагийн мэдээг авч ажиллах
6. Яаралтай шийдэх асуудал гарсан үед Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын 94100223, хамгаалалтын захиргааны 88004617, 99256479, 99852385 дугаарын утсанд яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авч ажиллах